



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.17 № 03 595

ганай _____ -ийн № _____ -г


Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан БШУЯ/20240102231 дугаартай Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д ижил төстэй бараа нь санал болгож буй тоног төхөөрөмж болон түүнтэй дүйцэхүйц бараа нийлүүлсэн туршлагыг тооцно гэсэн шалгуур тавьсан байна. Туршлагын шаардлагад Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлснийг тооцож үзэх үү.	Өгөгдлийн хүснэгтийн 18.1-д “Ижил төстэй бараа гэдэг нь санал болгож буй тоног төхөөрөмж болон түүнтэй дүйцэхүйц бараа нийлүүлсэн туршлагыг тооцно” гэж заасан бөгөөд хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг ижил төстэй бараанд тооцох эсэхийг үнэлгээний хорооны хурлаар шийдвэрлэх тул хариулт өгөх боломжгүй байна.
2	Захиалагчийн техникийн тодорхойлолтын 2-т байгаа гутал ариутгагч төхөөрөмж нь хэт ягаан туяагаар шарж нян бактерийг устгадаг, зэвэрдэггүй, ган материалтай, автомат болон гар ажиллагаатай, гутлын шороог буулгах сойзтой байна гэж заасан байна. Гэтэл гутлын улыг хэт ягаан туяагаар шарж ариутгадаг, гутлын шороог буулгах сойз нэг цогцоор байдаг төхөөрөмж үйлдвэрлэгдээгүй байна. Гутлын шороог буулгах сойз нь тусдаа юм уу эсвэл энэ нь хамтдаа нэг төхөөрөмж /хэт ягаан туяагаар ариутгагч болон тоос буулгах сойз/ гэж ойлгох уу. Захиалагч тал оролцогчдод техникийн тодорхойлолтоо ойлгомжтой байдлаар /хэмжээ, болон хүчин чадал, авах хүсэлтэй байгаа гутал ариутгагч төхөөрөмжийн жишиг зураг/ өгнө үү.	Техникийн тодорхойлолтыг боловсруулсан байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хавсралтаар хүргүүллээ.

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.” гэсний дагуу тендер ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.





Г НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР Г

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон,
Энхтайваны өргөн чөлөө 10а,
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас: (976) 7011 3033
Цахим хуудас: www.edub.edu.mn

2024.04.17 № 3/692
танай _____-ны № _____-г

Г Мэдээлэл хүргүүлэх тухай Г

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт хэрэгжиж буй “Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг)” дугаартай төсөл, арга хэмжээний талаар захиалагчаас тодруулахад бохирдол буулгах сойз, ариутгах туяа зэрэг нь нэг төхөөрөмжид багтсан байх тухай ирүүлсэн байна. Уг төхөөрөмжтэй адил төстэй төхөөрөмжийн мэдээлэл одоогоор байхгүй байна.



Нийслэлийн Боловсролын газар
Захиргааны хэлтэс
Хэлтсийн дарга
Оргих БАДАМСЭРЭЭЖИД
2024.04.17 14:29